



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар A/881

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, ажилтнуудыг шалгаруулж, урамшуулал олгох журам”-ыг нэгдүгээр, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг хоёрдугаар, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг шалгаруулах шалгуурыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг шалгаруулж, урамшуулах ажлыг чанартай зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэжаргал/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

3.Уг захирамж батлагдсантай холбоотойгоор “Журам батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/342 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч /Ш.Анхмаа/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111020004071

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
...сарын 27-ны өдрийн
...захирамжийн 1 дүгээр
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮНГ ҮНЭЛЭХ, ЭМНЭЛГИЙН ШИЛДЭГ МЭРГЭЖИЛТЭН,
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНУУДЫГ ШАЛГАРУУЛЖ,
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний соёл, эзлтэй орчин бүрдүүлэх, шинэ бутээлч ажил, санал санаачилгыг дэмжсэн урамшууллын тогтолцоог нэвтрүүлэхэд мөрдлөг болгоно.

1.2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх замаар иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго нь оршино.

Хоёр. Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд баримтлах зарчим

2.1. Эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмж, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үнд:

2.1.1. Ил тод, нээлттэй, хамт олны оролцоог хангасан байх.

2.1.2. Үйл ажиллагааны үр дүнг үнэлэх аргачлал нь хэмжигдэхүйц, бодитой, ажлын ачааллыг харгалзсан, ойлгомжтой, тодорхой үр дүнд үндэслэсэн байх;

Гурав. Хамрах хүрээ

3.1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагууд /Дүүргийн эрүүл мэндийн төв, Дүүргийн нэгдсэн эмнэлэг, Амаржих газар, Нийслэлийн тусгай мэргэжлийн төв, Тосгоны эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв/ тэдгээрт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд.

Дөрөв. Ажлын зохион байгуулалт

4.1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, урамшуулал олгох ажлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар хариуцах ба ажлын хэсэг томилон үнэлгээг хийнэ.

4.2. Ажлын хэсэгт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсийн мэргэжилтнийг оролцуулж болно.

4.3. Ажлын хэсэг журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын ирүүлсэн тайлан, материал, статистик үзүүлэлтэд үнэлгээ өгөх ба шаардлагатай тохиолдолд байгууллага дээр очиж үнэлгээ хийнэ.

4.4. Эрүүл мэндийн шилдэг байгууллага, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг 2 үе шаттайгаар шалгаруулах ба квотыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батална.

4.4.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх 1 дүгээр шатны шалгаруулалтыг Дүүргийн эрүүл мэндийн төв хийж шалгарсан байгууллагуудын материалыг квотын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

4.4.2. Өрхийн шилдэг эмч, сувилгачийг шалгаруулах 1 дүгээр шатны шалгаруулалтыг Дүүргийн эрүүл мэндийн төв хийж шалгарсан шилдэг эмч, сувилгачийн материалыг квотын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

4.4.3. Эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг шалгаруулах 1 дүгээр шатны шалгаруулалтыг эрүүл мэндийн байгууллагууд энэхүү журмын шалгуурын дагуу өөрсдөө зохион байгуулж, шалгарсан эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын материалыг квотын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

4.4.4. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас томилогдсон ажлын хэсэг уг журамд заасан шалгуурын дагуу 2 дугаар шатны шалгаруулалтыг явуулж урамшуулал олгох шилдэг эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг тодруулна.

4.5. Шалгаруулалтын дүн, тайланг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулна.

Тав. Үйл ажиллагааны үр дүнг дүгнэх аргачлал

5.1. Ажлын хэсэг нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнг журмын хавсралтад заасан шалгуур үзүүлэлтээр доорх байдлаар дүгнэнэ. Үүнд:

5.1.1. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

- “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);
- “тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь);
- “эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь);
- “үр дүнгүй”-зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь);
- “үнэлэх боломжгүй”-зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол.

5.1.2. Үйл ажиллагааны үр дүнг үнэлэх чанарын шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ өмнөх оны түвшин болон нийслэлийн дундаж түвшинтэй харьцуулж үнэлнэ.

5.1.3. Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурьдсан үнэлгээний аль нэгийг өгнө.

Бүрэн хангалттай	90.0 - 100.0
Хангалттай	80.0 - 89.9
Ажил сайжруулах шаардлагатай	70.0 – 79.9
Хангалтгүй	0.0 - 69.9

Зургаа. Урамшуулал олгох

6.1. Үйл ажиллагааны үр дүнгээр “Бүрэн хангальтай”, “Хангальтай” үнэлгээтэйгээр үнэлэгдсэн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг шалгаруулан дараах мөнгөн урамшуулал олгоно. Үүнд:

6.1.1. Байгууллагад - Нийт урамшууллын 50 хүртэлх хувь

6.1.2. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудад нийт урамшууллын сангийн 50-иас доошгүй хувь /Үнээс их эмч, мэргэжилтэн 45% хүртэл, бага эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд- 45%, бусад ажиллагсад 10% /

6.2. Үнэлгээний дүнг харгалзан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг 3 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.

6.3. Тосгоны эрүүл мэндийн төвөөс бусад эрүүл мэндийн байгууллагуудыг онооны дарааллаар жагсаан дараах урамшууллыг олгоно. Үүнд:

1-р байр 1 байгууллага /Байгууллагад олгогдох мөнгөн урамшууллын 27 хүртэлх хувь/

2-р байр 2 байгууллага /Байгууллага тус бүрт олгогдох мөнгөн урамшууллын 15 хүртэлх хувь/

3-р байр 3 байгууллага /Байгууллага тус бүрт олгогдох мөнгөн урамшууллын 10 хүртэлх хувь/-ыг тус тус шалгаруулж урамшуулна.

6.4. Өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг онооны дарааллаар жагсаан дараах урамшууллыг олгоно. Үүнд:

1-р байр 1 байгууллага /Байгууллагад олгогдох мөнгөн урамшууллын 4 хүртэлх хувь/

2-р байр 2 байгууллага /Байгууллага тус бүрт олгогдох мөнгөн урамшууллын 3 хүртэлх хувь/

3-р байр 3 байгууллага /Байгууллага тус бүрт олгогдох мөнгөн урамшууллын 1 хүртэлх хувь/

6.5. Эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг дараах номинациар шалгаруулна. Үүнд:

- Шилдэг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад ажилтан

- Өрх, тосгоны шилдэг эмч, сувилагч

6.6. Байгууллагад олгосон мөнгөн урамшууллын 20 хүртэлх хувийг эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын урамшуулалд, 20 хүртэлх хувийг тухайн байгууллагын удирдлагын багийн шагналд, 60-аас доошгүй хувийг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх урт болон богино хугацааны гадаад, дотоодын сургалтад хамруулах, ээлтэй ажлын байр, иргэд, үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл орчныг бүрдүүлэх зэрэгт зарцуулна.

6.7. Эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, урамшуулал олгох ажлыг жилд 1 удаа зохион байгуулж олгоно.

6.8 Мөнгөн урамшууллын зарцуулалт, үр дүнгийн талаар байгууллагын ажилтнууддаа мэдээлж, Нийслэлийн эрүүл мэндийн газарт дараа оны нэгдүгээр улиралд багтаан тайлагнана.

6.9. Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон байгууллагууд урамшуулалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын мэдээллийн санг үүсгэн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын “UB ERP” удирдлагын системд байршуулна.

Долоо. Санхүүжилт

7.1. Үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн урамшууллыг жил бүрийн төсөвт тусгуулах ажлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар хариуцна.

7.2. Урамшууллыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын саналыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар олгоно.

Найм. Хариуцлага

8.1. Урамшуулалд хамрагдах эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын холбогдох бичиг баримт, ажлын тайланг дутуу ирүүлсэн, санаатай бөгөөд санамсаргүй байдлаар орхигдуулсан, хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд хариуцлагыг тухайн байгууллагын удирдлага хүлээнэ.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- 000 ---

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
сарын 08-ны өдрийн
захирамжийн 2 дугаар
хавсралт

**ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
1.	-Оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт арга аргачлалыг нэвтрүүлсэн, нэр төрлийг нь нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлууд -Үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр шинээр санаачилсан бүтээлч ажлууд	30%
2.	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	5%
3.	Байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	5%
4.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд	60%
Нийт үнэлгээ		100%

1. Дүүргийн эрүүл мэндийн төвийг үнэлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Эхийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлтөд/		
2.	0-1 насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/		
3.	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/		
4.	0-5 насны хүүхдийн суурь өвчлөлтэй хүүхдийн тоо, үүнээс эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, хувь		
5.	Хоног болоогүй нас баралтын тоо, үүнээс 8-24 цагийн доторх нас баралтын тоо, хувь		
6.	Үндсэн оношийн зөрүүний хувь		
7.	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь /Төрөх тасагтай ЭМТ-д хамааралтай/		
8.	Амьгүй төрөлтийн түвшин /1000 төрөлтөд/		
9.	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин		
10.	Үр хөндөлтийн түвшин		
11.	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн түвшин		
12.	Гэрийн төрөлтийн хувь		
13.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь		
14.	Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь		
15.	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь		
16.	Хяналтгүй төрөлтийн хувь		

17.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
18.	Чихрийн шижин хэв шинж -2 өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
19.	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 20 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
20.	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
21.	Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь		
22.	Элэгний В,С вирусын эрт илрүүлгийн хувь		
23.	Дархлаажуулалтын хамралтыг 95%-д хүргэсэн ΘЭМТ-ийн хувь		
24.	Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралтын хувь		
25.	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн хувь		
26.	Хепатит В вирусын халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
27.	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь /Төрөх тасагтай ЭМТ-д хамааралтай/		
28.	Үүнээс ёсвөр насны эмэгтэйн төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь /Төрөх тасагтай ЭМТ-д хамааралтай/		
29.	Төрсний дараах эхний 1 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь /Төрөх тасагтай ЭМТ-д хамааралтай/		
30.	Төрсний дараах эхний 5 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь /Төрөх тасагтай ЭМТ-д хамааралтай/		
31.	Нярайн скрининг шинжилгээний хувь /Төрөл тус бүрээр/ /Төрөх тасагтай ЭМТ-д хамааралтай/		
32.	Нийт мэс засалд давтан хагалгааны эзлэх хувь		
33.	Мэс заслын дараах хүндрэлийн эзлэх хувь		
34.	Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сурьеэгийн өвчтний тоо, хувь, үүнээс эмчилгээг бүрэн дуусгаж эдгэрсэн тоо, хувь		
35.	Өсвөр насны 1000 хүнд ногдох БЗДХ-ын түвшин		
36.	Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо		
37.	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо, үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хувь, эрүүлжсэн хүний тоо, хувь		
38.	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тоо /ХӨСҮТ-өөр нотлогдсон./		
39.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
40.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		
41.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтад хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сурьеэ, иммунологи- В,С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		

42.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлгэдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, залруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		
-----	---	--	--

2. Нэгдсэн эмнэлгийг үнэлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Хоног болоогүй нас баралтын тоо, үүнээс 8-24 цагийн доторх нас баралтын тоо, хувь		
2.	Үндсэн оношийн зөрүүний хувь		
3.	0-1 насны эндэгдэл /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/		
4.	1-5 насны эндэгдэл /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/		
5.	Задлан шинжилгээний хувь /Зайлшгүй орох шаардлагатай тохиолдлоос тооцно/		
6.	Мэс заслын дараах хүндрэлийн хувь		
7.	Мэс заслын давтан хагалгааны хувь		
8.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
9.	Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдварын тоо /ХӨСҮТ-ээр нотлогдсон./		
10.	Хепатит В вирусын халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
11.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		
12.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтад хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сүрьеэз, иммунологи- В, С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		
13.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлгэдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, залруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		

3. Амаржих газрыг үнэлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Хоног болоогүй нас баралтын тоо, үүнээс 8-24 цагийн доторх нас баралтын тоо, хувь		
2.	Үндсэн оношийн зөрүүний хувь		
3.	Товлолт дархлаажуулалтад хамрагдсан хувь /төвлөлтийн ангилаар/	Сүрьеэз Хепатит В вирусийн эсрэг Үүнээс: Хепатит В вирусийн эсрэг дархлаажуулалтад 24 цагийн дотор хамрагдсан нярай хүүхдийн эзлэх хувь Халдварт саа	
4.	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн хувь		
5.	Нийт төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь		
6.	Үүнээс ёсвөр насны эмэгтэйн төрөлтөөс кесар хагалгаагаар шийдвэрлэсэн төрөлтийн хувь		
7.	Кесар хагалгааны дараах давтан мэс заслын хувь		

8.	28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайг амьдруулсан хувь		
9.	Төрсний дараах эхний 1 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь		
10.	Төрсний дараах эхний 5 минутад Апгарын оноо 3 болон түүнээс доош байсан нярайн эзлэх хувь		
11.	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)		
12.	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)		
13.	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 нийт төрөлтөд		
14.	Үр хөндөлтийн дараах хүндрэлийн хувь		
15.	Задлан шинжилгээний хувь		
16.	Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусlamжийн хэрэгжилтийн хувь		
17.	Нярайн скрининг шинжилгээний хувь /Төрөл тус бүрээр/		
18.	Нийт төрөлтөнд төрөх болон төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийн эзлэх хувь		
19.	Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвартын тоо /ХӨСҮТ-ээр нотлогдсон./		
20.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
21.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангальтын хувь		
22.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		
23.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтад хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сүрьеэз, иммунологи-В, С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		
24.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлэгдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, залруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		

4. Тосгоны эрүүл мэндийн төвийг үнэлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх ОН	Тайлант ОН
1.	Хоног болоогүй нас баралтын тоо, үүнээс 8-24 цагийн доторх нас баралтын тоо, хувь		
2.	0-1 насны хүүхдийн эндэгдлийн түвшин /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/		
3.	1-5 насны хүүхдийн эндэгдлийн түвшин /тухайн насны эмнэлэгт хэвтэж эмчлэгдсэн хүүхдийн тоонд харьцуулсан хувь/		
4.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь		
5.	Тосгоны эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь		
6.	Жирэмсний эрт хяналтын хувь		
7.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
8.	Чихрийн шижин хэв шинж -2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
9.	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
10.	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		

11.	Элэгний В, С вирусын эрт илрүүлгийн хувь		
12.	Нийт дуудлагаас 20 минутын очилтын хувь		
13.	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн БЗДХ-ын тохиолдлын тоо, үүнээс эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хувь, эрүүлжсэн хүний тоо, хувь		
14.	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь /товлолын ангиллаар/, /Гачуурт тосгоны ЭМТ-өөс бусдад хамааралтай/		
15.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
16.	0-5 насны хүүхдийн суурь өвчлөлтэй хүүхдийн тоо, үүнээс эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, хувь		
17.	Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвартын тоо /ХӨСҮТ-ээр нотлогдсон./		
18.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
19.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
20.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		
21.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтад хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сүрьеэ, иммунологи-В, С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		
22.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлэгдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, запруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		

5. Наркологийн эмнэлгийг үнэлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Хоног болоогүй нас баралтын тоо, үүнээс 8-24 цагийн доторх нас баралтын тоо, хувь		
2.	Үндсэн оношийн зөрүүний хувь		
3.	Сэтгэл заслын 4С эмчилгээнд хамрагдсан өвчтнүүдээс эмчилгээг бүрэн дуусгасан өвчтний тоо хувь		
4.	Дахилтаас сэргийлэх эмчилгээнд хамрагдсан өвчтний тоо, хувь		
5.	Мэдрэг эмийн эмчилгээнд хамруулсан эмчлүүлэгчдийн тоо, хувь		
6.	Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвартын тоо /ХӨСҮТ-ээр нотлогдсон./		
7.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
8.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
9.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		
10.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтад хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сүрьеэ, иммунологи-В, С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		
11.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлэгдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, запруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		

**6. Энэрэл эмнэлгийг үнэлэх эрүүл мэндийн тусlamж
үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд**

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Хоног болоогүй нас баралтын тоо, үүнээс 8-24 цагийн доторхи нас баралтын тоо, хувь		
2.	Үндсэн оношийн зөрүүний хувь		
3.	Нийт хэвтэн эмчлүүлэгчдээс эмзэг бүлгийн иргэдийн эзлэх хувь		
4.	Сүрьеэ өвчний улмаас эмчилгээнд хамрагдсан хүний тоо, эдгэрэлтийн хувь		
5.	Эмзэг бүлгийн иргэдээс БЗДХ, ХДХВ-ийн халдвартын шинжилгээнд хамрагдсан хүний тоо, хувь		
6.	БЗДХ-ын халдвартын сэжигтэй өвчтөнөөс эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн тоо, хувь		
7.	Задлан шинжилгээний хувь		
8.	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай нэхэн үржихүйн насын эмэгтэйчүүдэд тусlamж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо, ЖСА-д хамруулсан хувь /спираль, тариа/		
9.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь		
10.	Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвартын тоо /ХӨСҮТ-ээр нотлогдсон./		
11.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно./		
12.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
13.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		
14.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтанд хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сүрьеэ, иммунологи-В, С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		
15.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлэгдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, залруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		

**7. Нийслэлийн Шүд эрүү нүүрний төвийг үнэлэх эрүүл
мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд**

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.	Авсан, эмчилсэн шүдний харьцаа: - 0-6 нас - 6-аас дээш нас		
2.	Мэс ажилбарын дараах хүндрэлийн хувь		
3.	Мэс ажилбараас бусад эмчилгээний дараах хүндрэлийн хувь		
4.	Эрүүлжилтийн хувь		
5.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь		
6.	Нийт үйлчлүүлсэн 0-12 насны хүүхдийн тоо, үүнээс амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөөг өгсөн хувь /эрүүл ахуйч эмчийн зөвлөгөө хамаарна./		
7.	Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвартын тоо /ХӨСҮТ-ээр нотлогдсон./		
8.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		

9.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
10.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		

8. Нийслэлийн Түргэн тусlamжийн төвийг үнэлэх
эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх	Тайлант
		ОН	ОН
1.	Яаралтай дуудлагаас 20 минутын очилтын хувь		
2.	Яаралтай бус дуудлагын 20 минутаас дээшхи дуудлагын хулээгдлийн эзлэх хувь		
3.	Амилуулах суурь тусlamж үзүүлсэн хүний тоо, түүнээс амилуулсан хувь		
4.	Төрөлтийн дуудлагын тоо, үүнээс төрөлтийг амжилттай удирдсан болон төрүүлсэн тоо		
5.	Түргэн тусlamжийн үйлчилгээтэй холбоотой гарсан алдаа, зөрчил, санал гомдолын тоо, түүнд дүгнэлт хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн хувь		
6.	Автомашины техникийн бэлэн байдлын хувь		
7.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
8.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
9.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		

9. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийг үнэлэх
эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Өмнөх	Тайлант
		ОН	ОН
1.	Идэвхтэй тандалтаар шинээр илрүүлсэн голомтын тоо		
2.	Тухайн жилд төлөвлөгдсөн тандалтын гүйцэтгэлийн хувь		
3.	Хүн амын дундах зоонозын өвчний халдварталтын хувь		
4.	Лабораторийн оношийг баталгаажуулсан хувь		
5.	Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулалтад хамруулсан хувь (нэр төрлөөр)		
6.	Байгууллага, аж ахуй нэгж, ажилтнуудад мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгсөн байдал (давтамж, тоо)		
7.	Зоонозын халдварт өвчний дуудлагад цаг хугацаандаа үйлчилсэн тоо		
8.	Зоонозын халдвартын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг лабораторийн шинжилгээнд хамруулсан хувь		
9.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
10.	Лабораторийн шинжилгээний гадаад чанарын хяналтанд хамрагдсан байдал /Биохими, гематологи, нян судлал, сурьеэ, иммунологи-В, С вирус ХДХВ, тэмбүү, иммуногематологи/		
11.	Лабораторийн гадаад чанарын хяналтаар үнэлэгдсэн үнэлгээний хувь /чиглэл тус бүрээр/, гадаад чанарын хяналтын үнэлгээнд дүгнэлт хийж, залруулах, сайжруулах талаар хийсэн үйл ажиллагаа		

10. Өрхийн эрүүл мэндийн төвийг үнэлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлтүүд	Өмнөх он	Тайлант он
1.	Нийт үзлэгээс гэрийн идэвхтэй эргэлтийн эзлэх хувь		
2.	0-1 насны хүүхдийн эндэгдлийн тувшин		
3.	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тувшин		
4.	0-5 насны хүүхдийн суурь өвчлөлтэй хүүхдийн тоо, үүнээс эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, хувь		
5.	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь		
6.	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь		
7.	Эхийн эндэгдэл		
8.	Гэрийн төрөлт		
9.	Амьгүй төрөлт		
10.	Хяналтгүй төрөлт		
11.	Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо		
12.	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн тувшин		
13.	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн тувшин		
14.	Өсвөр насны 1000 хүнд ногдох БЗДХ-ын тувшин		
15.	ӨЭМТ-д эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтний тоо, эдгэрэлтийн тоо, хувь		
16.	Жирэмсэн эмэгтэйчүүдийг тэмбүүгийн сорилд хамруулсан хувь		
17.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
18.	Чихрийн шижин хэв шинж -2 өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь		
19.	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
20.	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь		
21.	Элэгний В,С вирусын эрт илрүүлгийн хувь		
22.	Хепатит В вирусын халдвартын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо, хувь /хамрагдвал зохих нийт ажилчдаас тооцно/		
23.	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь		
24.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь		

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
08 зурагт сарын 27-ны өдрийн
А1881 багт захирамжийн 3 дугаар
хавсралт

ЭМНЭЛГИЙН ШИЛДЭГ МЭРГЭЖИЛТЭН, ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНУУДЫГ ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР

Нэг. Зорилго:

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрийг бодитой үнэлэх, нийгмийн баталгааг хангах, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Тавигдах шаардлага нь нийтлэг болон тусгай шалгуураас бүрдэнэ.

2.1. Нийтлэг шаардлага:

- 2.1.1. Тухайн байгууллагад мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх
- 2.1.2. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх, багц цагийн бүрдэлт хангасан байх.
- 2.1.3. Мэргэжлийн алдаа, зөрчил гаргаагүй байх.
- 2.1.4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, харьцаа хандлагын зөрчилгүй байх.

2.2. Тусгай шаардлага:

2.2.1. “Шилдэг эмч” шалгаруулах шалгуур

- Шинэлэг, бүтээлч ажил санаачлан хийж, тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлж, тодорхой үр дүн гаргасан байх.
- Тусlamж үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд биечлэн идэвхтэй оролцсон байх /ижил мэргэжилтний үзлэг, дотоод хяналт/
- Эрүүл мэндийн салбарын болон байгууллагын эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх.
- Ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарсан байх /эхийн эндэгдэл, өвчтний эдгэрэл, гэх мэт/
- Мэдлэг мэргэжил болон багаар ажиллах чадвараа дээшлүүлж байгууллагын соёлд хувь нэмрээ оруулсан байх.
- Үйлчлүүлэгчийн болон хамт олны санал, талархлыг хүлээсэн, ёс зүйн зөрчил гаргаагүй байх.

2.2.2. “Шилдэг сувилагч, тусгай мэргэжилтэн” шалгаруулах шалгуур

- Шинэлэг, бүтээлч ажил санаачлан хийж, тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлж, тодорхой үр дүн гаргасан байх.
- Тусlamж үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд биечлэн идэвхтэй оролцсон байх. /ижил мэргэжилтний үзлэг дотоодын хяналтын ажлууд гэх мэт/
- Ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарсан байх.

- Онол практикийн бага хурал, ажил мэргэжлийн уралдаанд амжилттай оролцсон байх.
- Мэдлэг мэргэжил болон багаар ажиллах чадвараа дээшлүүлж байгууллагын соёлд хувь нэмрээ оруулсан байх.
- Үйлчлүүлэгчийн болон хамт олны санал, талархлыг хүлээсэн, ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байх.

2.2.3."Өрх, тосгоны шилдэг эмч" шалгаруулах шалгуур

- ~~- Шинэлэг, бүтээлч ажлыг санаачлан тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлж, тодорхой үр дүнд хүрсэн байх.~~
- Тусlamж үйлчилгээний чанар, хүrtээмж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэхэд биечлэн идэвхтэй оролцсон байх /ижил мэргэжилтний үзлэг, дотоод хяналтууд гэх мэт/
- Ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарсан байх.
- Жирэмсэн эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд үзүүлэх тусlamж үйлчилгээний хүrtээмж, чанарт үнэлэлт дүгнэлт өгч тодорхой асуудал дэвшиүүлэн ажилласан байх.
- Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг үр дүнтэй, шинэлэг байдлаар зохион байгуулж үр дүнг тооцсон байх.
- Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлгийг үр дүнтэй зохион байгуулсан байх.
- Мэдлэг мэргэжил болон багаар ажиллах чадвараа дээшлүүлж байгууллагын соёлд хувь нэмрээ оруулсан байх.
- Ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байх.

2.2.4."Өрх, тосгоны шилдэг сувилагч" шалгаруулах шалгуур

- Шинэлэг, бүтээлч ажил санаачлан хийж, тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлж, тодорхой үр дүн гаргасан байх.
- Тусlamж үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд биечлэн идэвхтэй оролцсон байх /ижил мэргэжилтний үзлэг дотоод хяналтууд гэх мэт/
- Ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарсан байх.
- Жирэмсэн эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд үзүүлэх сувилахуйн тусlamж үйлчилгээний хүrtээмж, чанарт үнэлэлт дүгнэлт өгч тодорхой асуудал дэвшиүүлэн ажилласан байх.
- Эрүүл мэндийн сургалт сурталчилгааг үр дүнтэй, шинэлэг байдлаар зохион байгуулж, үр дүнг тооцсон байх.
- Мэдлэг мэргэжил болон багаар ажиллах чадвараа дээшлүүлж байгууллагын соёлд хувь нэмрээ оруулсан байх.
- Үйлчлүүлэгчийн болон хорооны иргэдийн санал, талархлыг хүлээсэн, ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байх.

2.2.5."Шилдэг бусад ажилтан" шалгаруулах шалгуур

- Ажилдаа бүтээлч шинэлэг, санал санаачилгыг хэрэгжүүлж үр дүнг тооцсон байх.
- Ажлын үзүүлэлтүүдэд чанарын ахиц дэвшил гарсан байх.
- Мэдлэг, мэргэжил болон багаар ажиллах чадвараа дээшлүүлж байгууллагын соёлд хувь нэмрээ оруулсан байх.
- Сайн туршлага нэвтрүүлэх, бусдад ажлаа танилцуулах чиглэлээр санаачилгатай ажилласан байх.

Гурав. Шалгаруулалтын материал хүлээн авах

3.1. Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг шалгаруулах ажлыг нээлттэйгээр зохион байгуулж, аливаа маргаан, гомдол санал үүсэхээс сэргийлж ажиллана.

3.2. Эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн шилдэг мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудад нэр дэвшүүлэхэд дараах материалыг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлнэ. Үүнд:

3.2.1.Шалгаруулалтад дараах материалыг бүрдүүлэн ирүүлнэ:

- а) Байгууллагын албан бичиг
- б) Шилдэг эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнаар шалгаруулах болсон үндэслэл, дүгнэлт
- в) Төрийн албан хаагчийн нэгдүгээр маягтыг бөглөж ирүүлэх
- г) Хамт олны хурлын тэмдэглэл/ Шалгаруулалт явуулсан тухай илтгэх хуудас/
- д) Ёс зүйн салбар хороо, хэсгийн хорооны тодорхойлолт
- е) Шилдэг эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд нэр дэвшүүлсэн ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар /ажилд орсон болон албан тушаалын бичилт хийсэн хуудсыг оруулж өгнө/
- ё) Урамшуулал олгох шалгуур бүрийг хангасныг нотлох материалыг хавсаргана

--- 000 ---